

ШИНЭ КОРОНАВИРУС ӨВЧНИЙ ТАЛААР СУРАЛЦАЖ ТҮҮНЭЭС ХАМГААЛЬЯ !

One Health Research Forum




Edit: KH, DS. Narration: YM, SM

COVID-19 тархалтын байдал, ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ (Олон улс болон Япон улсын түвшинд)

<出典> 4月8日時点 WHO・各国政府発表

各国の感染状況


■ 報告なし ■ 1人以上 ■ 100人以上 ■ 1,000人以上 ■ 10,000人以上 ■ 100,000人以上



※中国および直近1週間で30,000人以上感染者数が増加した国名を記載しています


<出典> 4月11日時点 厚生労働省発表

都道府県別感染者数




COVID-19: Өвчний нэр SARS-CoV2: Үүсгэгч

国内感染者数





年齢階級別陽性者数



***20~50 насныхан илүү өртөмтгий : шинж
тэмдэг илрэхгүй тохиолдол ч байна.**

Вирус гэж юу вэ?

Вирус нь бактериас (μm) жижиг , нанометрээр (nm) хэмжигддэг.



Коронавирус

Диаметр $100\sim 200\text{ nm}$

Онцлог	Вирус	Бактери
Бүтцийн нэгж	Вирус	Бактери
Удмын мэдээлэл	DNA эсвэл RNA	DNA
Биеэ даасан ургалт	Үгүй	Тийм
Энергийн нийлэгшил (АТР)	Үгүй	Тийм
Уургийн нийлэгшил	Үгүй	Тийм

Вирус нь амьд эсэд бэхлэгдсэнээр түүний дотор үржих боломжтой.



SARS-CoV2 гэдэг нь ?

Severe **A**cute **R**espiratory **S**yndrome **C**oronavirus **2** = Амьсгалын замын хурц хэлбэрийн хам шинж- Коронавирус 2

Коронавирус нь хүн болон амьтанд халдвар үүсгэнэ. Муур, гахай, үхэр зэрэг амьтанд халдвар үүсгэх вирусын төрөл гэж байна.



Хүнд халдвар үүсгэх коронавирусын 7 төрөл байна.

Үүнээс: 4-н төрөл нь энгийн ханиадны үүсгэгч вирус

3-н төрөл нь хүнд хэлбэрийн шинж тэмдэг үзүүлнэ.

SARS коронавирус (SARS-CoV, SARS-CoV2)

MERS коронавирус



Хэрхэн вирусын халдвар тархах вэ ?



Вирус цацагдаж, халдвар тархах эрсдэл нь ойролцоогоор 2 метр орчмын зайнд
Цацагдалтын хүрээг багасгах, түүнээс хамгаалж сэргийлэх нь чухал !



- ✓ Вирус нүд, ам болон хамраар халдварлагдана.
- ✓ Мөн вирусаар бохирлогдсон гараар дамжин нүд, ам болон хамраар халдвар орно.




Маск нь вирус цацагдаж, тархахаас хамгаалахад чухал нөлөөтэй !
Ханиах, найтаах, халуурах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд маск зүүх




Халдвараас биеэ хамгаалахын тулд !



Гар нь вируст өртөхдөө амархан.
Гарыг байнга угааж, үргэлж цэвэр байлгах нь чухал !



Халдварын
чадвартай



Халдварын
чадваргүй

Вирусын мембраныг эвдэж чадах халдваргүйжүүлэлт нь үр дүнтэй

- Спиртээр (60%-аас дээш) халдваргүйжүүлэх
- Гараа савангаар угаах (30 секундээс дээш)
- Хаалганы хонх, бариул, ширээ зэргийг 0.05% хлорын уусмалаар арчиж цэвэрлэх

Дархлааг хэвийн байлгах
(Вирустэй тэмцэх биемахбодь бүтээх)



Хоолны шим тэжээлийн зохистой
байдалд анхаарах, унтаж амрахыг
зөв зохицуулах



Бөөгнөрч
цугларахгүй байх



Хамар, аманд халдвар
орохоос хамгаалах

Нүүрэнд гар
хүрэхгүй байх

Анхаарах чухал зүйлс

Хувь хүн халдвар авахаас сэргийлэх

- Гарыг хангалттай сайн угаах, олон хүн цугларсан газраас зайлсхийх, өрөө тасалгааг агааржуулах

Бусад хүмүүст халдвар тараахаас болгоомжлох

- Таны үйлдэл танил хүмүүст халдвар тарааж болзошгүй. Өөрийгөө халдварлагдсан байж магадгүй гэдэгт анхаарах !
- Шаардлагагүй тохиолдолд гадуур явахаас зайлсхийж халдвараас хамгаалах !
- Онцгой байдал зарласан газраас буцаж ирсний дараа хэсэг хугацаагаар гадуур явахаас зайлсхийх, биеийн байдлыг хянах.

Сэжигтэй тохиолдолд гадуур явахаас татгалзах

- Халуурах, ханиах, нус гойжих, мэдрэхүйн өөрчлөлт зэрэг ханиадны шинж тэмдэг илрэх үед тусгай өрөөнд байрлах,
- Өдөр тутам биеийн байдлыг хянах,
- Шинж тэмдэг илэрсэн найз, нөхдийн гэрт зочлохоос зайлсхийх
- Халдвар тээгчтэй шууд харьцахаас зайлсхийх, маск зүүх, гар угаах .

Магадгүй халдвар авсан байх ? !

- 37.5°C дээш халуурах нь 4 -өөс дээш өдөр үргэлжлэх, ядрах, амьсгалахад хүндрэлтэй болох шинж тэмдэг илэрсэн тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагатай утсаар холбогдон зөвлөгөө, тусламж авах.
- Дээрх шинж тэмдэг илэрсэн тохиолдолд шууд эмнэлэг явахгүй байхыг анхаарах.



Доорх цахим хаягийг ашиглан сүүлийн үеийн мэдээ авах боломжтой

- Япон улсын эрүүл мэндийн яам
 - https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000164708_00001.html
 - <https://www.forth.go.jp/topics/fragment1.html>
 - <https://www.forth.go.jp/useful/attention/index.html>
- Япон улсын халдварт өвчин судлалын хүрээлэн
 - <https://www.niid.go.jp/niid/ja/>
- Япон улсын засгийн газар
 - <https://corona.go.jp/prevention/>
- Япон улсын гадаад харилцааны яам
 - <https://www.anzen.mofa.go.jp>
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
 - <https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019>

